

МОНГОЛЫН МАЛ СҮРГИЙН ӨСӨЛТИЙН ТОВЧ ТОЙМ

Х. Дашдондов

Монголчууд эрт дээр үеэс голлон эрхлэж ирсэн аж ахуйн үндсэн салбар нь уламжлалт мал аж ахуй юм.

Монгол орны хөгжилд тансаг нутгийн минь чимэг болсон таван эрдэнэ» гэрийн үндсэн таван төрлийн мал сүрэг, тухайлбал тэмээ, үхэр, адуу, хонь, ямаа онцгой ач холбогдолтой байдаг. Эдгээр таван төрлийн малыг түүхчдийн үзэж байгаагаар Монголчууд бүр манай эриний урьдах мянган жилийн тэртээгээс эрхэмлэж байсан нь тодорхой баримтаар нотлогддог билээ. Бас гадаадын эрдэмтэд ч тэгж үздэг бөгөөд жишээлбэл 1247 онд Монголд ирсэн Италийн Плано Карпини тэмдэглэлдээ дээрх таван төрлийн малыг бас тоочин бичсэн байдаг.

Монголын нутаг дээр нүүдлийн мал аж ахуйн бэлчээрийн өвөрмөц систем ч ойролцоогоор 4000-4500 жилийн өмнөөс буй болсон түүхтэй. Ер нь төв азийн, тухайлбал монголын малын төрлийн ба үүлдрийн бүрэлдэхүүн, түүнийг маллах арга барил нь Азийн бусад бүс нутаг болон Европынхоос маш их онцлогтой бөгөөд эрт дээр үеэс хэвшиж тогтсон байдлаа илүү сайн хадгалснаараа нилээд олон талын давуутай, хөдөлмөр бага зарцуулдаг, бүтээгдэхүүн нь чанарлаг, хямд байдаг. Тухайлбал, мах нь амтлаг, шүүслэг; сүү нь өтгөн, тослог ихтэй өнгө, үнэр аятайхан, элчит чанараар илүү; ноос нь урт, ноолуурлаг, элчлэг дулаан, суналт ихтэй; арьс шир нь элдүүр даадаг, суналт сайтай; яс нь хатуу учир сайн түүхий эд болдог онцлогтой. Ялангуяа байгалийн тансаг янз бүрийн өвс ургамлыг бэлчээрээр өөрөө олж ирдэг учир мах, өөх, сүү шим нь хүний зөвхөн хүнсний хэрэгцээг хангаад зогсдоггүй бас бие махбодийг эрүүлжүүлдэг эмчилгээний ач холбогдолтой байдаг. Энэ бүхэн нь байгаль, цаг уурын онцлогтой амьд шүтэлцээтэй байдгийн тод илрэл мөн.

Монголд бэлчээрийн мал аж ахуйн нүүдлийн систем буй болсон байгаль-цаг уурын нөхцөл

Монголд мал аж ахуйг бэлчээрээр нүүдлэн эрхлэхэд байгалийн өвөрмөц онцлогтой. Монгол орон бол далайн түвшнээс өндөрт өргөгдсөн тал бүрээрээ өндөр уулаар хүрээлэгдсэн эх газрын эрс тэс уур амьсгалтай, өндөр уул, уудам тал, өргөн говь нутагтай учир харьцангуй хур тунадас багатай, жил бүхэн ургамал нь сэргэн ургадаг учир жилийн дөрвөн улиралд бэлчээрээ сэлгүүлэн нүүж ашиглах боломжтой юм.

Тэгээд ч монголын нутагт 2000 гаруй төрлийн өвс ургамалтай, ус хужир ихтэй учир мал идээшлэх таатай нөхцөлтэй. Монголын эрдэмтэд эх нутгаа мал аж ахуйн үйлдвэрлэлийн байршилд тохиромжтой байдлаар нь байгаль-газар зүйн таван үндсэн бүс болгон хуваадаг ба эдгээр бүсүүдэд таван төрлийн мал нь биологийнхоо онцлогоор эрт дээр үеэс тархаж байршсан түүхэн уламжлалтай нь үйлдвэрлэл явуулахад их чухал нөлөөтэй байдаг. Үүнд:

1. Монголын баруун талаар орших Алтайн өндөр уулын бүсэнд Монгол Алтай ба Говь-Алтайн баруунаасаа зүүн тийшээ үргэлжилсэн уулархаг их нутаг багтдаг бөгөөд 3000—3500 метрийн өндөрт оршдог,

бог бод малд, ялангуяа хонь, үхэрт тохиромжтой өвс ургамлын баялаг их нөөцтэй. Энэ бүсэнд хонь, үхэр зонхилон байрлана.

2. Мөн их нуурын хотгор нь монголын баруун талд Монгол Алтай ба Хангайн нурууны хооронд орших бөгөөд далайн түвшнээс 1200 метрт өргөгдсөн юм. Энд Увс нуур, Хар ус нуур, Хиргис нуур, Хар нуур, Дөрөө нуур зэрэг ус чийгээр элбэгийн дээр Шарга, Бэгэрийн говийн сайхан нутаг багтдаг нь өвс ургамлаар баялаг байх үндсэн шинж төрхийг бүрдүүлдэг учир таван төрлийн малд ихээхэн тохиромжтой болно.

3. Монголын хойт ба төв хэсгийг Хангай Хэнтийн уулын бүс эзлэх бөгөөд энд Монголын хамгийн том гүн нуур Хөвсгөл, олон тооны голууд байдаг нь ургамал амьтны ургаж амьдрах бүх нөхцөлийг бүрдүүлжээ. Энэхүү бүс нутагт уулаасаа тал уруугаа аажим налуу хэлбэрээр 3500—1500 метрт буусан нь жилийн дөрвөн улиралд өвс ургамал, ус голыг зохицуулан ашиглаж үхэр, адуу, хонь, ямааг өсгөж үржүүлэх асар их боломжтой билээ. Иймээс энд тэмээнээс бусад дөрвөн төрлийн малыг голлон байршуулахад тохирох 1300-1400 төрлийн өвс ургамалтай.

4. Монголын дорнод тал Хэнтийн нурууны чиглэлээр зүүн өмнө тийшээ цэлийж тогтсон 1500—1000 метрийн түвшинд орших учир хонь, ямаа, адуунд илүү тохиромжтой нарийн өвс ихтэй нутаг болно. Энд Хэрлэнгийн тэгш тал, монголын дорнод тэгш талууд оршино.

5. Говийн бүс нутаг нь Монголын өмнөт хэсгийг эзэлдэг бөгөөд далайн түвшнээс 700-1800 метрийн өндөрт оршино. Энд ургадаг 600 төрлийн өвс ургамал нь хонь, ямаа, тэмээнд онцгой тохиромжтой байдаг. Энэ бүхнээс үзэхэд монгол нутаг нь баруун талаараа өндөр уулаар, баруун хойт, хойт талаараа уулаар, төв хэсгээрээ уул талаар зүүн хэсгээрээ тэгш талаар, өмнөд хэсгээрээ говь нутгаар зонхилсон нь таван төрлийн малыг бэлчээрээр нүүдэллүүлэн ашиглах асар их боломжтой билээ. Ер нь монгол нутагт одоогийн байгаа малыг бараг хоёр дахин өсгөх байгалийн өвс ургамал, бэлчээр нутаг, ус хужирын үлэмж нөөцтэй гэж монголын эрдэмтэд тооцдог нь зүй ёсны асуудал мөн. Монголын цаг уурын гурим ч гэсэн малыг бэлчээрээр жилийн дөрвөн улиралд нүүж ашиглах сайхан нөхцөлийг бүрдүүлжээ.

Малын тооны өсөлт

Монгол мал бол биологи, физиологийнхоо онцлогийн хувьд маш их өсөх чадвар, амьдрах тэвчээр бүхий онцлог шинжтэй юм.

1990 он бол монголын мал сүрэг тооны үзүүлэлтээр өндөрт гарсан он бөгөөд ер нь ч энэ цагаан морин жил нь монголын улс төрийн тогтолцоонд ч, эдийн засгийн тогтолцоонд ч шинэчлэлт өөрчлөлт хийсэн монголын сэргэн мандалтын эхний жил бөгөөд энэ жил өнгөрсөн гучаад жилд хүрээгүй олон тооны малтай болсноор эрчимт гараагаа эхлэж байгаад монголчууд бид их баяртай байна.

Өнгөрсөн 70 гаруй жилд манай орны нийт 5 хошуу мал сүргийн тоо 2,6 дахин өссөний дотор тэмээ 2,4 дахин, адуу 1,9 дахин, үхэр 2,6 дахин, хонь 2,6 дахин, ямаа 3,4 дахин тус тус өслөө. Жилийн эцэст мал тоолдог болсон 1961 оноос хойшхи сүүлийн 30 жилд малын тоо анх удаагаа хорин таван саяд хүрлээ. Ялангуяа мал сүргийн эх сурвалж болсон хээлтэгч малын тоо бараг 12,0 саяд хүрсэн нь дээрх хугацаанд байгаагүй үзүүлэлт бөгөөд энэ нь цаашид улам их өсөхийн бааз суурь болно. Сүүлийн арваад жилд дунджаар 10-аад сая хээлтэгчээс 8,5—9,0 сая гаруй төл хүлээн авч байсан бол одоо 12,0 хээлтэгчээс 10—11 сая төл авах бүрэн боломжтой болов. Энэ нь зөвхөн 1990 онд 1989 оныхоос тэмээнээс бусад дөрвөн төрлийн мал төрөл тус бүр дээр өсч нийт малын

Монголын мал сүргийн тоо 1918—1990 онд

(мян. толгойгоор)

Он	Бүх мал	үүнээс				
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1918	9645,6	228,7	1150,5	1078,4	5700,1	1487,9
1930	23676,2	480,9	1566,9	1887,3	15660,3	4080,8
1950	22702,2	844,2	2317,0	1987,8	12574,6	4978,6
1970	22574,9	633,5	2317,9	2107,8	13311,7	4204,0
1990	25400,0	533,0	2200,0	2800,0	14900,0	5000,0

тоо 800 мянга, хээлтэгч 300 мянгаар нэмэгдсэнээс тодорхой байна. Мөн гахай, шувуу бусад амьтан ч өссөөр байна.

Малын чанарын өсөлт

Малын тоо толгойг эрхэмлэхийн хамт үүлдэр угсааг сайжруулах ажлыг анхаарч нутгийн сонгомол малыг цэврээр өсгөх, бусад орнуудаас өндөр ашиг шимт үүлдрийн мал авчирч үржүүлэх, эрлийзжүүлэх, шинэ үүлдэр буй болгох зэрэг олон янзын арга хэмжээг байнга авсаар ирсэн нь малын ашиг шимийг нэмэгдүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, таваарлаг чанарыг ихээхэн дээшлүүлсэн сайхан үр дүнд хүрсээр ирлээ. 1940 оныхтой зэрэгцүүлэхэд 1990 онд бэлтгэсэн мах, сүү, цөцгийн тос янз бүрийн ноос, ноолуур 3-8 дахин өссөн жишээтэй байна. Түүнчлэн нэгжээс ашигласан ашиг шим чихээхэн нэмэгдсээр байна.

Мал аж ахуй бол эдийн засгийн зонхилох үндсэн суурь салбарын нэг мөн. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд ч мал аж ахуйн үйлдвэрлэлийн үүрэг, ач холбогдол улам их болох нь лавтай. Ийнхүү хорин таван сая малтай болсон энэ үед улс орон маань зах зээлийн эдийн засагт шилжин орж байна.

Улс орны эдийн засагт таван төрлийн мал сүргийн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг харилцан адилгүй байдаг. Одоогийн байдлаар мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний тэн хагасаас илүүг хонины, дөрөвний нэг орчмыг үхрийнх, 10 илүү хувийг ямааных, үлдэх хэсгийг тэмээ, адууны аж ахуй өгч байна. Гэвч малын толгой бүрээр авч үзвэл байдал бас өөр болж, хамгийн их таваарын бүтээгдэхүүнийг тэмээнээс авч байна. Нэг толгой тэмээний таваарын бүтээгдэхүүнийг 100 гэж үзвэл үхрийнх 97, хониных 32, ямааны 22, адууных 21 хувь тус тус болж байна.

Ялгаатай төрлийн болон харилцан адилгүй тоо толгойтой мал сүргийг бодлож нэг адил нэгжид оруулж улмаар тэдгээрийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь илүү зөв үр дүн өгөх учиртай юм.

Ийнхүү үзвэл хамгийн их таваарлаг аж ахуй нь хонь, ямааных, үхрийнх, дараа нь тэмээ, адууных орж байна. Эд бүгд нь ямар мал сүрэг монголын мал аж ахуйд эдийн засгийн ач холбогдлоороо хир байртай болохыг харуулж байна.

Монгол улс бол 1000 хүнд ноогдох малын тоогоор дэлхийд дээгүүр орнуудын нэг мөн. Одоо манай улс 1000 хүнд ноогдох адуу, ямааны тоогоор дэлхийд нэгдүгээрт, тэмээгээр Сомали, Мавританы дараа гуравдугаарт, үхрээр хамгийн олон үхэртэй гэгддэг орнуудын тоонд Шинэ Зеланд, Аргентин, Ирланд, Австралийн дараа тавдугаарт, хониор Шинэ Зеланд, Австралийн дараа гуравдугаарт орж дэлхийн дунджаас 38 дахин дээгүүр үзүүлэлттэй явж зах зээлийн эдийн засагт шилжиж байна. Сүүлийн хориод жилд манай орны нэг хүнд жилд дунджаар 90—99 кг мах хэрэглэж байгаа нь дэлхийд дээгүүр орох үзүүлэлт юм. Гэвч энэ нь манай орны хүн ардын эрт дээр үеэс хэрэглэж ирсэн зан заншил, байгаль, цаг уурын нөхцөл зэргээс шалтгаалах онцлогтой байдаг. Ялангуяа манай улсын махны үйлдвэрлэлд голлох байрыг (50-иас илүү хувийг) хонь, ямааны мах эзэлдэг болохоор эдгээрийн хувь дэлхийд харьцангуй өндөр байдаг талтай. Гэтэл дэлхийн бусад ихэнх орны махны үйлдвэрлэлд гахайн мах дээгүүр байр эзэлдэг ба хонь, ямааны мах тун бага хувьтай байдаг.

Иймээс цаашид өөрийн орны онцлог ба дэлхийн зах зээлийн хэрэгцээтэй уялдуулан мал сүргийнхээ бүтцийг улам зохистой болгох шаардлагатай.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

ЭДИЙН ЗАСГИЙН 2000 ОНЫ ПРОГНОЗ*

	1987-2000 оны хөгжлийн өсөлт %	ҮНБ (тэрбум) (доллар)	Нэг хүнд ноогдох ҮНБ (доллар)	Аж үйлдвэрийн бүтэц (%)		
				х. а. а. ойн а. а загас --" --"	хүнд үйлдвэр	үйлчилгээ
1. Өмнөд солонгос	7,0	286	5800	9	51	40
2. Тайван	7,0	235	9800	6	49	46
3. Гонконг	7,0	111	18500	1	27	72
4. Сингапур	7,0	49	16300	2	33	65
5. Азийн шинээр аж үйлдвэржсэн орнууд (нийтдээ)	7,0	680	8300	6	45	49
6. Тайланд	6,5	103	1600	13	31	56
7. Малайзи	6,0	61	2900	7	34	59
8. Индонези	5,7	147	700	24	39	37
9. Филиппин	6,0	73	1000	20	40	40
10. АСЕАН-ы 4 орон (нийтдээ)	6,0	384	1000	17	36	46

*Азийн эдийн засаг 2001 онд. Тооёо, Кэйзай Шимпоошя То-кио, 1989 он, 42-р тал